



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 05 сарын 06 өдөр

Дугаар А/310

Булган сум

Гэрээ байгуулах эрх олгох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.2, 66 дугаар зүйлийн 66.1, Засгийн газрын худалдан авах ажиллагаанд баримтлах төсөвт өртгийн дээд хязгаар тогтоох тухай 2024 оны 02 дугаар тогтоол, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны XIX хуралдааны “Булган аймгийн 2024 оны төсөв батлах тухай” XIX/08 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын “Шинэ хөгжлийн зам” үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай 2020 оны II/04 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Дэлхийн “Алтаргана 2024” наадмын бэлтгэл ажлыг хангахад шаардагдах 8 ханатай сийлбэртэй гэр нийлүүлэх ажлыг 20,000,000 (хорин сая) төгрөгөөр “Юу Би Икс” ХХК-тай гэрээ байгуулах эрхийг олгож, хяналт тавьж хүлээн авахыг Нийгмийн бодлогын хэлтэс (М.Батчимэг)-т үүрэг болгосугай.

2. Гэрээнд заасан барааг чанарын өндөр түвшинд нийлүүлж хүлээлгэн өгөхийг “Юу Би Икс” ХХК-ны захирал (Т.Болорхүү)-д даалгасугай.

3. Санхүүжилтийг аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн “Алтаргана 2024” арга хэмжээний төлөвлөгдсөн хөрөнгөөс санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Д.Батцогт)-д зөвшөөрсүгэй.

4. Гэрээний биелэлтийн дагуу хүлээн авсан барааг бүртгэж, тайлагнахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийтлэг үйлчилгээний албаны дарга (Х.Энхбаатар), Ахлах нягтлан бодогч (Д.Баясгалан)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА  Б.АРИУН-ЭРДЭНЭ

